



**“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙ 2017 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Аудитын код: САГ-2018/66/СТА-ТӨХК**

**АУДИТЫН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

**САГ-ын захирал бөгөөд, Тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг**  
Утас: 261885  
Цахимхаяг: [naranchimegts@audit.mn](mailto:naranchimegts@audit.mn)

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан,  
зорилтот түвшний биелэлт

**Аудитын менежер: Я.Самбууням**  
Утас: 260512  
Цахимхаяг: [sambuunyamya@audit.gov.mn](mailto:sambuunyamya@audit.gov.mn)

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр**  
Бага тойруу 6, Улаанбаатар 46  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн**  
**Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд**  
Утас:99901517

Улаанбаатар хот



Агуулга

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	1
2. АУДИТЫН ТАЙЛАН	1
2.1 ОРШИЛ	1
2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	1
2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	2
2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН	3
2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН	3
2.6 ДОТООД ХЯНАЛТ	4
2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	4
2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	4
2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	4
2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	5
2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР	5
2.11.1 Санхүүгийн тайлагналын талаар	5
2.11.2 Хөрөнгийн тооцоо бодолтын талаар	5
2.11.3 Үндсэн хөрөнгийн талаар	6
2.11.5 Авлагын талаар	6
2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР	7
2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	7
2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД	7
2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	7
2.16 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	7
3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	10
3.1 Авлагын талаар	11
3.2 Бараа материалын талаар	11
3.3 Үндсэн хөрөнгийн талаар	11
3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар	12
3.5 Авлагын талаар	12
3.6 Эздийн өмчийн талаар	13
4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	14
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	16
4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний гүйцэтгэл	



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/678  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН  
ЗАХИРАЛ Б.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь, үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kherreg\Yawsan\_Bichig\2018\0315SAG5.Docx

070964

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**


**Үүрэг, хариуцлага**

“Дулаан Шарын гол” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг гүйцэтгэх захирал Б.Энхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлого, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн шинэчлэгдэн батлагдсан дансны заавар, төлөвлөгөөг мөрдөх, хөрөнгийн тооллогын үр дүнг тооцоо бодож актаар баталгаажуулах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг баримтжуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн дансны бичилтийг залруулах шийдвэр гаргах зэргийг тусгаж зөвлөмж өгсөн болно.


Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно

### 2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2018/66/СТА-ТӨХК/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эрчим хүчний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүйнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.



“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-аас 2018 оны 03 дугаар сарын 10-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд, аудитор С.Галсанчоймбол, аудиторын туслах ажилтан Х.Уранчимэг Г.Дашбалжир нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Дулаан Шарын гол” ТӨХК нь 2017 оны санхүүгийн тайланг “Цэгцтөв богд аудит” ХХК-д 2018 оны 02 дугаар 09-ний өдөр 01/40 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

“Цэгцтөв богд аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-аас 2018 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.


## **2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

“Дулаан Шарын гол” ТӨХК нь Монгол Улсын Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Зөрчлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн зорилтыг “Хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүч, ундны цэвэр усаар тасралтгүй найдвартай хангаж, бохир усыг ариутган татан зайлуулах ба эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажиллах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь “дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, цэвэр ус олборлох, түгээх, бохир ус татан зайлуулах, суурин газрын ус хангамжийн худаг, ус түгээх цэг, зөөврийн ус хангамж болон орон сууцны барилга байгууламжийн цэвэр, бохир ус, дулаан цахилгааны шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төв, ус хангамж, ариутгал татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ үзүүлэх” явдал юм.



Дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж зорилгоо хэрэгжүүлэхийн тулд компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулан мөрдөж ажилласан байна.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## **2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 45-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 46 дугаар тушаалаар “Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдөх”-өөр баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тогтоолууд Сангийн яамнаас батлагдан гарсан журмуудын өөрчлөлтийг тусгасан байна.


Бид “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Дулаан Шарын гол” ТӨХК санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулахдаа Санхүүгийн “Даймонд” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Уг програм нь СТОУС болон Нягтлан бодох бүртгэлийн онцлогт нийцсэн тул Сангийн яамнаас ашиглах зөвшөөрөл авсан байна.

## **2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН**

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин хянаж материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор, түвшинг 2 хувиар



тогтоож хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 49.1 сая төгрөг гэж тооцов. Шинж чанар, орчин нөхцөлийн хувьд материаллаг шинжтэй зүйл илрээгүй болно.

## 2.6 ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаад дотоод хяналтын эрсдлийг бага гэж үзлээ.

## 2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

2017 оны батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу гарган санхүүжүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна.

“Дулаан Шарын гол” ТӨХК нь 2017 онд улсын төсвөөс 500.0 сая төгрөгийн татаас авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 2,455.2 сая төгрөг, хүүний орлого 1.1 сая төгрөг, бусад орлого 61.5 сая төгрөг нийт 2,517.8 сая төгрөгийн орлого олж 2,601.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, 83.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 196.2 сая төгрөг буюу 29.9 хувиар бууруулсан байна.

## 2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны хуульд заасны дагуу цаглабарт хугацаанд жил, улирал, сар бүр холбогдох мэдээллийг оруулсан байна. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу “Дулаан Шарын гол” ТӨХК нь [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим сайтад I) төсөв/гүйцэтгэл; II) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; III) бусад; цэсэнд хуульд заасан хугацааны дагуу мэдээлэх үүрэгтэй. Тус компани 2017 онд шилэн дансны тухай хууль, журмын дагуу холбогдох мэдээллийг цахим хуудсанд мэдээлсэн боловч Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.1. “худалдан авах ажиллагааны...жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар мэдээлнэ” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

## 2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу 10 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 45 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс авлага, бараа материал, цалин хөлс дансны гүйлгээтэй холбоотой зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



## 2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, орлого, зардлын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 85 хувийг эзэлж байна.

## 2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

Аудитын явцад аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### 2.11.1 Санхүүгийн тайлагналын талаар

Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан дансны зааврыг мөрдөж санхүүгийн тайлан гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан дансны заавар, төлөвлөгөөг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх

### 2.11.2 Хөрөнгийн тооцоо бодолтын талаар

Бараа материал, үндсэн хөрөнгө, шатахууны жилийн эцсийн тооллогын үр дүнг тооцоо бодоогүй, акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулж, тооцоог бодон, акт үйлдэж, үр дүнг тайлант оны санхүүгийн тайланд тусгаж байх зөвлөмж өгөх

### **2.11.3 Үндсэн хөрөнгийн талаар**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 122 нэр төрлийн 511.3 сая төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө ашиглагдаж байгаа нь НББОУС-16.44-д “Хөрөнгөнд агуулагдаж байгаа эдийн засгийн өгөөжийг аж ахуйн нэгж зарцуулж байдаг. Уг зарцуулгын улмаас хөрөнгийн өртөг нь байгуулсан элэгдлийн шимтгэлийн хэмжээгээр буурч байдаг. Хөрөнгийн үлдэгдэл өртгөөс үнэ цэнэ нь илүү байх тохиолдолд ч элэгдлийн шимтгэлийг байгуулдаг” гэж заасан, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглахдаа дахин үнэлгээ хийлгэх эсэхийг шийдвэрлэх зөвлөмж өгөх

### **2.11.4 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар**

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэгдсэн 12.2 сая төгрөг нь ямар хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдсэнээс үүссэн, үндсэн хөрөнгийн бүртгэлд уг хөрөнгө байгаа нь тодорхойгүй зэрэг нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Данс бүртгэлийн үлдэгдлийг баталгаажуулах, нотлох баримтыг бүрдүүлэх, хяналт тавих зөвлөмж өгөх

### **2.11.5 Авлагын талаар**

Тайлант оны авлагын үлдэгдэл 25.2 сая төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**


Авлагын үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулах зөвлөмж өгөх

### **2.11.6 Татварын тооцоололын талаар**

Ажилчдад олгосон хоолны үнийн хөнгөлөлтөөс Хувь хүний орлогын албан татвар 0.4 сая төгрөг дутуу суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна”, 15.1.3-т “бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор”, 15.3-т “Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т “заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Ажилчдад олгосон хоолны үнийн хөнгөлөлтөөс хувь хүний орлогын албан татвар дутуу суутгасан 0,4 сая төгрөгийг төлүүлэхээр акт тогтоох.



### **2.11.7 Эздийн өмчийн талаар**

2012 оноос хойш Засгийн газрын нөөц сан болон БХБЯ,ТЭХЯ, Төрийн Өмчийн Хороо, Эрчим хүчний газар гэсэн байгууллагуудын санхүүжилтээр бэлтгэгдсэн 1,287.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэн эздийн өмчид давхар бичилт хийхдээ Эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Дээд шатны байгууллагуудаас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн дансны бичилтийг залруулах шийдвэр гаргуулах зөвлөмж өгөх

### **2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР**

Аудитын явцад материаллаг бус хэмжээний санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн алдааг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

### **2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**


“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### **2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 37.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс хувь хүний орлогын албан татварын тооцооллын алдааны улмаас дутуу суутгасан 0.4 сая төгрөгийг төлүүлэхээр акт тогтоож, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй 6 зөвлөмжийг Менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлэв.

### **2.16 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг “Ди Эй Би Жи Аудит” ХХК гүйцэтгэж 8 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Шүүхийн шийдвэр гарч хэрэгсэхгүй болгосон 7.4 сая төгрөгийн авлагыг алдагдлаар хүлээн зөвшөөрч, залруулан бүртгэх зөвлөмж Төрийн Аудитын Байгууллага зөрчилгүй санал дүгнэлт хуралдаанаар хэлэлцээд



хараат бус аудитын дүгнэлт гаргуулан данснаас хасалт хийх шийдвэр гаргасан бөгөөд уг дүгнэлтийг гаргуулаагүй, данснаас хасаагүй байна.

### **САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Дулаан Шарын гол” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж дүгнэн “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт гаргалаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 15 хуудас, хавсралтууд 9 хуудсыг тус тус хавсаргав.

### **АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН  
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ..... Н.ЦЭРЭНХАНД Огноо:

### **БЭЛТГЭСЭН:**

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР..... С.ГАЛСАНЧОЙМБОЛ Огноо:





**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## “ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

**САГ-ын захирал, Тэргүүлэх аудитор**

Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахимхаяг: [naranchimegts@audit.mn](mailto:naranchimegts@audit.mn)

**Аудитын менежер: Я.Самбууням**

Утас: 261885

Цахимхаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр**

Бага тойруу 6, Улаанбаатар 46

**“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн**

**Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд**

Утас:99901517

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Дансны зааврын талаар.....1

Асуудал 2

Бараа материалын.....2

Асуудал 3

Үндсэн хөрөнгийн талаар.....3

Асуудал 4

Хөрөнгийн дахин үнэлгээний талаар.....4

### Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 5.

Авлагын талаар.....5

Асуудал 6

Эздийн өмчийн талаар.....6

Улаанбаатар хот



### 3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдсэн ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Дулаан Шарын гол” ТӨХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3.1 Дансны зааврын талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### **Аудитын ажиглалт**

Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан дансны зааврыг мөрдөж санхүүгийн тайлан гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам,заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

#### **Аудитын зөвлөмж**

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан дансны заавар, төлөвлөгөөг мөрдөж хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Үндэсний Аудитын Газарт ирүүлэх

#### **Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

### 3.2 Бараа материалын талаар

### Тэргүүлэх ач холбогдол №2

#### **Аудитын ажиглалт**

Бараа материал, үндсэн хөрөнгө, шатахууны жилийн эцсийн тооллогоор тооцоо бодоогүй, акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

#### **Аудитын зөвлөмж**

Хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулж, тооцоог бодон, акт үйлдэж, үр дүнг тайлант оны санхүүгийн тайланд тусгаж хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Үндэсний Аудитын Газарт ирүүлэх

#### **Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

### 3.3 Үндсэн хөрөнгийн талаар


### Тэргүүлэх ач холбогдол №3

#### **Аудитын ажиглалт**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 122 нэр төрлийн 511,3 сая төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө ашиглагдаж

#### **Аудитын зөвлөмж**

СТОУС17-д зааснаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг цаашид



байгаа нь НББОУС-16.44-д Хөрөнгөнд агуулагдаж байгаа эдийн засгийн өгөөжийг аж ахуйн нэгж зарцуулж байдаг. Уг зарцуулгын улмаас хөрөнгийн өртөг нь байгуулсан элэгдлийн шимтгэлийн хэмжээгээр буурч байдаг. Хөрөнгийн үлдэгдэл өртгөөс үнэ цэнэ нь илүү байх тохиолдолд ч элэгдлийн шимтгэлийг байгуулдаг” гэж заасан, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

#### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

ашиглахдаа дахин үнэлгээ хийлгэх эсэхийг шийдвэрлэн хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэх.

#### **Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

### **3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний талаар**

### **Тэргүүлэх ач холбогдол №4**

#### **Аудитын ажиглалт**

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэгдсэн 12.2 сая төгрөг нь ямар хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдсэнээс үүссэн нь тодорхойгүй, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд уг хөрөнгө байгаа эсэх нь мэдэгдэхгүй байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

#### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

#### **Аудитын зөвлөмж**

Дахин үнэлгээний нэмэгдэл данс бүртгэл үлдэгдлийг баталгаажуулах, нотлох баримтыг бүрдүүлэх, хяналт тавьж ажиллан хэрэгжилтийг хянан 2018 оны 06 дугаар сарын 15-ний дотор Үндэсний Аудитын Газарт ирүүлэх

#### **Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

### **3.5 Авлагын талаар**


### **Тэргүүлэх ач холбогдол №5**

#### **Аудитын ажиглалт**

Тайлант онд авлага дансны оны эцсийн үлдэгдэл 25.2 сая төгрөг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн

#### **Аудитын зөвлөмж**

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулж 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор хэрэгжилтийг Үндэсний Аудитын газарт ирүүлэх





20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/  
зөв

**Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

**3.6 Эздийн өмчийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №6**

**Аудитын ажиглалт**

2012 оноос хойш Засгийн газрын нөөц сан болон БХБЯ, ТЭХЯ, Төрийн Өмчийн Хороо, Эрчим хүчний газар гэсэн байгууллагуудын санхүүжилтээр бэлтгэгдсэн 1,287.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэн эздийн өмчид давхар бичилт хийхдээ Эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байна. Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдаагүй байна

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/  
зөв

**Аудитын зөвлөмж**

Дээд шатны байгууллагуудаас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн дансны бичилтийг залруулах шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН


АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ ..... Н.ЦЭРЭНХАНД

Огноо:

БЭЛТГЭСЭН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР ..... С.ГАЛСАНЧОЙМБОЛ

Огноо:




#### 4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,888,922.12	18,774,569.30
Дансны авлага	183,837,902.68	344,151,757.67
Татвар НДШ-ийн авлага		
Бусад авлага	17,842,819.74	12,375,116.36
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бара материал	121,981,643.83	123,897,503.54
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	8,760,000.00	1,619,488.00
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>362,311,288.37</b>	<b>500,818,434.87</b>
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,434,722,848.77	1,450,532,278.32
Биет бус хөрөнгө	11,045,925.36	6,289,408.19
Биологийн хөрөнгө	3,230,000.00	3,230,000.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,448,998,774.13</b>	<b>1,460,051,686.51</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,811,310,062.50</b>	<b>1,960,870,121.38</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	720,613,050.47	984,741,519.91
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	134,984,297.66	207,350,598.98
НДШ-ийн өр	57,922,946.78	154,589,926.64
Банкны богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц өр төлбөр		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам		
.		
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>913,520,294.91</b>	<b>1,346,682,045.53</b>
Урт хугацаат өр төлбөр		



Урт хугацаат зээл		
Нөөц өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>913,520,294.91</b>	<b>1,346,682,045.53</b>
Эздийн өмч	2,272,713,862.35	2,272,713,862.35
Төрийн	2,272,713,862.35	2,272,713,862.35
Хувийн		
Хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,160,756.82	12,160,756.82
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг	1,487,852,253.36	1,287,852,253.36
Хуримтлагдсан ашиг	-2,874,937,104.94	-2,958,538,796.68
Эздийн өмчийн дүн	<b>897,789,767.59</b>	<b>614,188,075.85</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,811,310,062.50</b>	<b>1,960,870,121.38</b>

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>1. Борлуулалтын орлого (Цэвэр орлого)</b>	<b>2,453,087,735.12</b>	<b>2,455,246,615.21</b>
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,397,674,705.06	2,447,377,976.56
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>	<b>55,413,030.06</b>	<b>7,868,638.65</b>
4. Түрээсийн орлого		
5. Хүүний орлого		1,087,101.95
6. Ногдол ашгийн орлого		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого	74,520,040.97	61,487,372.72
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	54,954,898.68	60,643,096.02
11. Санхүүгийн зардал / ТУЗ-ын зардал/	35,259,352.42	41,288,525.97
12. Бусад зардал	43,523,486.21	52,004,472.88
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-3,804,666.28</b>	<b>-83,492,981.55</b>
19. Орлогын татварын зардал		108,710.19
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-3,804,666.28</b>	<b>-83,601,691.74</b>
<b>21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-3,804,666.28</b>	<b>-83,601,691.74</b>
<b>23. Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>-3,804,666.28</b>	<b>-83,601,691.74</b>
<b>25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан


Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,781,336,311.04</b>	<b>12,160,756.82</b>	<b>-2,887,144,519.10</b>	<b>1,979,229,804.67</b>	<b>885,582,353.43</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00		16,012,080.44	0.00	16,012,080.44
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,781,336,311.04</b>	<b>12,160,756.82</b>	<b>-2,871,132,438.66</b>	<b>1,979,229,804.67</b>	<b>901,594,433.87</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	491,377,551.31	0.00	0.00	-491,377,551.31	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,804,666.28	0.00	-3,804,666.28
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,272,713,862.35</b>	<b>12,160,756.82</b>	<b>-2,874,937,104.94</b>	<b>1,487,852,253.36</b>	<b>897,789,767.59</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,272,713,862.35</b>	<b>12,160,756.82</b>	<b>-2,874,937,104.94</b>	<b>1,487,852,253.36</b>	<b>897,789,767.59</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	200,000,000.00	200,000,000.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-83,601,691.74	0.00	-83,601,691.74
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,272,713,862.35</b>	<b>12,160,756.82</b>	<b>-2,958,538,796.68</b>	<b>1,287,852,253.36</b>	<b>614,188,075.85</b>

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>НИЙТ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b><u>1,987,439,563.88</u></b>	<b><u>1,827,685,954.68</u></b>
Бараа борлуулсан, ажил үйлчилгээ үзүүлсний орлого	1,483,518,243.18	1,323,474,502.62
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар	321,335.45	46,008,266.62
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,000,000.00	454,545,454.54
Бусад мөнгөн орлого	3,599,985.30	3,657,730.90
<b>НИЙТ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b><u>1,875,936,314.56</u></b>	<b><u>1,802,289,909.45</u></b>
Ажиллагчдад төлсөн	739,886,296.01	853,489,681.06
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,828,091.19	137,900,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	421,438,252.19	352,278,269.32
Ашиглалтын зардалд төлсөн	340,750,000.00	253,236,605.00
Тээвэр, шатахуун	41,058,806.22	37,789,365.04
Татварын байгууллагад төлсөн	123,765,756.90	148,372,991.57
Бусад мөнгөн зарлага	12,209,112.05	19,222,997.46
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>111,503,249.32</u></b>	<b><u>25,396,045.23</u></b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		1,087,101.95
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	83,377,089.83	37,597,500.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>(83,377,089.83)</u></b>	<b><u>(36,510,398.05)</u></b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас		



гаргаснаас хүлэн авсан		
Зээл авсан,өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авсан		
Төлсөн ногдол ашиг		
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	28,126,159.49	(11,114,352.82)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,762,762.63	29,888,922.12
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	29,888,922.12	18,774,569.30

“Дулаан Шарын гол” ТӨХК-ны 2017 оны Эдийн Засгийн үндсэн үзүүлэлт,  
зорилтот түвшний төлөвлөгөөний биелэлт

/сая.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2017 он		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Үйлдвэрлэх дулаан эрчим хүч (гкал)	40.9	39.8	(1.1)	97.2
	Дотоод хэрэгцээ ДЭХ (гкал)	3.2	2.9	0.3	89.6
	үгээлт ДЭХ (гкал)	37.7	36.9	0.8	97.8
2	Нийт орлого	2,057.3	2,063.3	5.9	100.3
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	2,005.0	1,998.1	(6.9)	99.7
3	Нийт зардал	2,837.1	2,601.4	(235.7)	91,7
	Үүнээс: Удирдлагын зардал	62.8	60.6	(2.2)	96.4
4	Татварын өмнөх ашиг (алдагдал)	(779.8)	(538.1)	(241.7)	69.0
5	Төсвийн санхүүжилт	500.0	500.0	0.0	100
6	Цэвэр ашиг (алдагдал)	(279.8)	(83.6)	196.2	29.9
7	Төсвийн төлбөрт нийт дүн	13.3	12.7	(0.6)	95.5
8	Ажиллагсдын тоо	117	117		100
9	Нийт цалингийн сан	1,087.2	991.3	(95.9)	91.2
10	Нэг ажилтны дундаж цалин	0.8	0.7		91.2
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	69.3	65.4	(3.9)	94,4
12	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.38	1.26	(0.1)	91,4
13	Жишмэл түлшний хувийн зарцуулалт (кг/гкал)	188.0	185.2	(2.8)	98.5
14	Нийт өр төлбөр	822.5	1,346.7	524.1	163.7
15	Нийт авлага	146.4	356.5	210.1	243.6
16	ХО,ИЗ,ТЗБАХ-ээр	177.7	171.5	(6.2)	95.9